



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 9/425

Мандалговь

Өсвөрийн улсын аварга шалгаруулах
үндэсний бөхийн барилдааны багш, дасгалжуулагчдад
хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.7, Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын норматив"-ын 2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Өсвөрийн улсын аварга шалгаруулах Үндэсний бөхийн барилдаанд бөхчүүдээ бэлтгэн ирж оролцсон багш, дасгалжуулагчдад аймгийн Засаг даргын зоог барьж, хүндэтгэл үзүүлсүгэй.

Хоёр. Хүндэтгэл үзүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Хүндэтгэлийн зоог барихад нийт 1406850 (Нэг сая дөрвөн зуун зургаан мянга найман зуун тавь) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

4881912-4

Аймгийн Засаг даргын 2019 оны
 12 дугаар сарын 06-ний өдрийн 425 дугаар
 захирамжийн хавсралт

БӨХИЙН ХҮЛЭЭН АВАЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Цай	53	300	26500
2	Цезарь салат	50	5500	275000
3	Броклитэй шөл	56	6500	364000
4	II дугаар хоол	52	9800	309600
5	Жимс	10	9125	91250
6	Ундаа	50	1600	80000
7	Жижиг ус	100	380	38000
8	Чихэр	9 уут	2500	22500
	ДҮН			1406850